



ГЭМТЭЛ СОГОГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2025 оны 04 сарын 04 өдөр

Дугаар 8/63

Улаанбаатар хот

“Амьд сорьцын эмгэг эд, эс судлалын шинжилгээний үйл явцын журам” батлах тухай

Эрүүл мэндийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/611 дүгээр тоот тушаалын арван нэгдүгээр хавсралт, Эрүүл мэндийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн А/447 дугаар тоот тушаалын хоёрдугаар хавсралт, Эрүүл мэндийн сайд, зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн А/410, А/165 дугаар тоот хамтарсан тушаал, Сангийн сайд, эрүүл мэндийн сайдын 2022 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 49, А/118 дугаар тоот хамтарсан тушаал, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 04 дүгээр тоот тогтоол, Монгол улсын стандарт MNS 7015:2023, Гэмтэл согог судлалын үндэсний төвийн 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн А/66 тоот тушаалыг тус тус үндэслэн тушаах нь:

1.“Амьд сорьцын эмгэг эд, эс судлалын шинжилгээний үйл явцын журам”-ийг хавсралтаар баталсугай.

2.Энэхүү тушаалыг мөрдөж ажиллахыг Гэмтэл согог судлалын үндэсний төв эмнэлэг болон Салбар эмнэлгийн нийт эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд үүрэг болгосугай.

3.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэл зүй хариуцсан дэд захирал (Л.Дагвадорж), Салбар эмнэлгийн Эмнэл зүй хариуцсан дэд захирал (О.Хишигсүрэн), Үйл ажиллагаа хариуцсан дэд захирал (Б.Батзориг), Сувилахуй хариуцсан дэд захирал (Г.Дэлхийцэцэг), Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын албаны дарга (Б.Бат-Оргил) нарт тус тус даалгасугай.

4.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Гэмтэл согог судлалын үндэсний төвийн захирлын 2018 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн А/100 дугаар тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРАЛ



Э.ГАЛБАДРАХ

1625010321

e:/my doc/2025/тушаал